



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.08.06 № 01/761
танай _____-ны № _____-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИРГЭДИЙН
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ЭЭЛЖИТ СОНГУУЛЬД ОРОЛЦОХ
БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ
НАМЖИЛЫН ЦЭРЭНЧИМЭД ТАНАА

Сонгуулийн мөрийн хөтөлбөр хуульд заасан шаардлагад нийцсэн талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5.4-т заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Намжилын Цэрэнчимэдийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцоо, судалгааг гарган хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага нь аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020 Төрийн аудит. Тулгуур зарчим, MNS 6817 - 6 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудитын зарчим, MNS 6817 - 8 : 2020 Төрийн аудит. Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль болон Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох бие даан нэр дэвшигч Намжилын Цэрэнчимэдийн ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлага болон холбогдох хууль, тогтоомжид тус тус нийцсэн байна.

Бие даан нэр дэвшигч Намжилын Цэрэнчимэдийн сонгуулийн мөрийн хөтөлбөр (... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: Бие даан нэр дэвшигч Намжилын Цэрэнчимэдэд.

Хувийг: Хөвсгөл аймгийн Сонгуулийн хороонд.

Хавсралт .! . хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



А.ЭРДЭНЭБААТАР


**ХӨВСГӨЛ АЙМГИЙН ИТХ-ЫН СОНГУУЛЬД БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ НАМЖИЛЫН
ЦЭРЭНЧИМЭД МИНИЙ МӨРИЙН ХӨТӨЛБӨР**

НЭГ: ЗОРИЛТ

Орон нутгийн хөгжил, бүтээн байгуулалт, хүн амын амьдралын чанарыг дээшлүүлж, нийтийн эрх ашгийг хамгаалсан санал санаачилгыг аймгийн ИТХ-д дэвшүүлж, түүнийг хэрэгжүүлэн ажиллах.

ХОЁР: ХӨТӨЛБӨРИЙН АГУУЛГА

1. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний зорилтот зах зээл, бэлтгэн нийлүүлэлтийн тогтолцоо, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлж, эдийн засгийн чадамж, үр өгөөжийг сайжруулна.
2. Хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийж бохирдол бага ялгаруулах, хог хаягдалгүй хэрэглээг дэмжих тогтолцоотой болсон байна.
3. Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, автоматаар татан авах (хог хаягдлыг татан авах шугам) технологийг нэвтрүүлсэн байна.
4. Хүүхдийн хөгжил, авьяас, ур чадвар, техник сэтгэлгээ, нийгмийн төлөвшлийг дэмжихэд эцэг, эхчүүдийн оролцоог нэмэгдүүлнэ.
5. Зорилтот бүлгийн иргэдийг дэмжсэн, бүтээмжтэй ажил, хөдөлмөр эрхлүүлж, олон талт хөгжил, хамгааллын цогц тогтолцоо бүрдсэн байна.
6. Орон сууц, ногоон байгууламжийн стандартыг мөрдөж, эрүүл баталгаат амьдрах орчныг бий болгоно.



МӨРИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛСАН

БИЕ ДААН НЭР ДЭВШИГЧ

Н. ЦЭРЭНЧИМЭД

0000000001